




СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, СТАТИСТИК МЭДЭЭ

Сүхбаатар сум
2021 оны 06 сарын 25

Тайлан бэлтгэсэн: Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар Дарга бөгөөд тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа Аудитын менежер Б.Батмөнх Хаяг: Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, аймгийн ЗДТГ-ын байрны өргөтгөл.	АГУУЛГА	
	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	2
	1. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....	3-5
	2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ.....	5-7
	3. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ.....	7-8
	4. НИЙЦЛИЙН АУДИТ.....	8
	5. ИТХ-ЫН ЗАХИАЛГА БОЛОН ӨӨРИЙН САНААЧИЛГААР ХИЙСЭН АУДИТ.....	8
	6. ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ДОТООД АЖИЛ	8
	7. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ...	9-15
	8. ДҮГНЭЛТ, САНАЛ.....	15-16
	9. ХАВСРАЛТУУД.....	16
		16

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР:

АТГ	Авлигатай тэмцэх газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗУГ	Захиргаа удирдлагын газар
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ММНБИ	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
СУГ	Стратеги удирдлагын газар
СТАУС	Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЭДТДҮТ	Тариалан эрхлэлтийг дэмжих техник дундын үйлчилгээний төв
УИХ	Улсын их хурал
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ХШҮДАГ	Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газар

Монгол улсын Ерөнхий аудиторын 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/235 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан болон статистик мэдээг боловсруулж, тайлагнах журам”-ын дагуу Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг нэгтгэн тайлагнаж байна. Үүнд:

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1 Ерөнхий зүйл: Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, төрийн аудитын байгууллагын “Аудитыг цахимжуулж, нэгтгэн удирдах тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх” үндсэн зорилт, төрийн аудитын байгууллагын болон тус газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд үйл ажиллагаагаа чиглүүлэн, эхний хагас жилд төлөвлөсөн ажлыг бүрэн хэрэгжүүлэн ажиллалаа.



Тус газар нь 2021 оны батлагдсан төсөв, орон тооны хүрээнд 12 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулсан бөгөөд Ерөнхий аудиторын 2021 оны 03 дүгээр сарын 23-ны өдрийн Б/11 дүгээр тушаалаар Т.Мөнхзул тус газрын аудитораар томилогдсон бол ахлах аудитор Ц.Отгонбаяр хүүхэд асрах чөлөөтэй байна.

2021 оны эхний хагас жилд хуанлийн 124 ажлын өдөр буюу 1488 хүн/өдөр ажиллахаас аудитын ачааллаас шалтгаалан нийт 132 өдөр, 1584 хүн/өдөр ажиллаж, 8 өдөр буюу 96 хүн/өдөр илүү ажилласан байна.

2021 оны батлагдсан төсвийн хүрээнд санхүүгийн тайлангийн аудитад туслах 2 гэрээт ажилтныг 3 сарын хугацаатайгаар авч ажиллуулсан бол байгууллагын нягтлан бодох бүртгэл, бичиг хэргийн ажил үүргийг гэрээт ажилтнаар гүйцэтгүүлж ирлээ.

Тайлант хугацаанд Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрх болон Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх заалтын хүрээнд 298 байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит, Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр 1 гүйцэтгэлийн аудитыг бүрэн хийж дуусгасан бол өөрийн төлөвлөгөө, хөтөлбөрөөр хийгдэж буй 2 гүйцэтгэлийн аудит хараахан эцэслэж, баталгаажаагүй байна.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас нийт 70 байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэхээр хараат бус аудитын 4 компанитай гэрээ байгуулж, гүйцэтгүүлэв.

1.2 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, түүний шийдвэрлэлт: Хийж гүйцэтгэсэн аудитиудаар нийт 761 төрлийн 17,777.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс бүртгэл тайлагналтай холбоотой 8,001.2 сая төгрөгийн алдааг залруулж, 192.9 сая төгрөгийн төлбөрийн акт, 7,634.1 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 1,949.4 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан, төлбөрийн актыг барагдуулаагүй, албан үүргээ хангалтгүй гүйцэтгэж, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд их хэмжээний материаллаг зөрчил гаргасан зэрэг 20 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлээ.

2021 оны эхний хагас жилд хийж гүйцэтгэсэн аудитиудын дүнгээр нийт 4,553.9 сая төгрөгийн аудитын үр өгөөжийг бүртгэн, харилцагчид хүлээн зөвшөөрснөөр төсвийн зардлын 1 төгрөгт ногдох үр өгөөж 23.1 төгрөгт хүрсэн байна.

1.3 Акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт: Ковид-19 халдварт цар тахал өвчний улмаас 2021 онд эхний хагас жилд хийж гүйцэтгэсэн аудитиудаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг объект дээр хүрч, баталгаажуулах боломжгүй байдалд хүрч актыг дансны хуулгаар, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг төсвийн захирагчдаас ирүүлсэн албан бичиг, нотлох баримтыг үндэслэн тооцсоноор 113.6 сая төгрөгийн акт, 3,528.1 сая төгрөгийн албан шаардлагыг биелүүлсэн тоо мэдээтэй тайлагнагдсан байна.



2020 оноос шилжин ирсэн акт, албан шаардлагын дүнг нэгтгэн авч үзвэл тайлант онд нийт 128.7 сая төгрөгийн акт, 6,925.4 сая төгрөгийн албан шаардлагын хэрэгжилтийг ханган, акт 87.0 хувийн, албан шаардлага 94.9 хувийн /хэрэгжих хугацаа болоогүй 60.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 3,739.5 сая төгрөгийн албан шаардлагыг тооцохгүйгээр/ сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага 100 хувийн биелэлттэй тайлагнагдлаа.

2021 оны эхний хагас жилд хийж гүйцэтгэсэн аудитуудын дүнд арвилан хэмнэх, үр ашиг, үр нөлөөг сайжруулах 8, бүртгэл тайлагналтай холбоотой 154, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 109, дотоод хяналтыг сайжруулах 50, бусад чиглэлээр 14 гэх мэтчилэн нийт 335 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлсний 88.7 хувь нь биелэгдсэн байна.



ХОЁР. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Санхүүгийн тайлангийн аудитад нийт 298 байгууллага, аж ахуйн нэгжийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хамруулахаар төлөвлөснөөс өөрийн аудиторуудаар 228, хараат бус аудитын 4 компаниар 70 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэсэн бөгөөд нийт 11 хүн 538 хүн өдөр ажиллан, ажлын ачааллаас шалтгаалан 528 цаг илүү ажиллалаа.


Аудитад хамрагдсан 298 санхүүгийн тайлангийн 30-д нь Ерөнхий аудиторын тушаалаар итгэл үзүүлж, 126 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан, 142 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт гаргасан байна.

Нийт дүгнэлт гаргасан байгууллагын 118-д нь “Зөрчилгүй”, 22-д нь “Хязгаарлалттай”, Шаамар сумын ТТЗ-ийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд “Сөрөг” дүгнэлт өгч, “ТЭДТДҮТ” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 748 төрлийн 15,012.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 8,001.2 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулан, 192.9 сая төгрөгийн төлбөрийн акт, 5,368.9 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 1,449.4 сая төгрөгийн зөрчилд 324 зүйлийн зөвлөмж өгөв.

Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан, төлбөрийн актыг барагдуулаагүй, албан үүргээ хангалтгүй гүйцэтгэж, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд их хэмжээний материаллаг зөрчил гаргасан зэрэг 20 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүллээ.

График №3 /сая төгрөг/



Актын биелэлт: Өмнөх оны үлдэгдлээс 4.1 сая төгрөг, тайлант онд тогтоогдсон актаас 113.6 сая төгрөгийг төлүүлснээр актын биелэлт /хугацаа болоогүй 60.4 сая төгрөгийн актыг тооцохгүйгээр/ 85.8 хувьтай тайлагнагдсан бөгөөд 79.3 сая төгрөгийн төлбөр дараа улиралд шилжээд байна.

Албан шаардлагын биелэлт: Тайлант хугацаанд нийт 5,368.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлснээс өмнөх оны үлдэгдлээс 337.1 сая төгрөгийн, тайлант хугацааны 1,322.9 сая төгрөгийн албан шаардлагын биелэлтийг хангуулж, 84.4 хувийн хэрэгжилттэй тайлагнагдсан бөгөөд сахилгын шийтгэл ногдуулах 20 албан шаардлагаас хугацаа болсон 16-г нь бүрэн биелүүлсэн байна.

Зөвлөмжийн хэрэгжилт: Аудитаар арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөг сайжруулах 8, бүртгэл тайлагналтай холбоотой 152, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 107, дотоод хяналтыг сайжруулах 47, бусад 10 зэрэг нийт 324 зөвлөмж өгснөөс 88.6 хувь болох 287-г нь хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,697.7 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцож, харилцагчаар хүлээн зөвшөөрүүлсэн ба аудитын бүх үе шатны ажлыг СТАУС программаар гүйцэтгэв.

Тус газар нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх санхүүгийн тайлангийн аудитад холбогдох хууль, стандарт, гарын авлагаас гадна "Төрийн аудитын байгууллагаас 2019-2020 онд санхүүгийн тайлангийн аудит хийх ерөнхий чиглэл"-ийг удирдлага болгон, хэрэгжилтийг ҮАГ-ын Аудитын нэгдүгээр газарт тайлагналаа. Үүнд:

- Аудитын үе шатны ажлыг хангалттай, зохистой нотлох баримтаар баталгаажуулж, аудитын төгсгөлд эмхэтгэн архивлав.
- Аудитын бүх үе шатны ажлуудад стандарт, журмын дагуу чанарын хяналтыг хэрэгжүүлж, холбогдох маягтаар баримтжуулав.
- Санхүүгийн тайлангийн аудитыг төсвийн орлого бүрдүүлэх, зардал бууруулах санал бэлтгэх ажилтай уялдуулан орлого нэмэгдүүлэх нөөц боломжийг

судлан, нормативт зардлуудын гүйцэтгэлд дүн шинжилгээ, судалгаа хийж, баримтжуулав.

- Уг аудитын хүрээнд Санхүүгийн аудитын газраас ирүүлсэн судалгааг маягт, хүснэгтийн дагуу гаргаж нэгтгүүлэв.
- Нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль, стандартын дагуу хөтөлж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөв.
- Аудитын зөвлөмжийн чанар, үр нөлөөг сайжруулах, стандартад нийцүүлэх чиглэлээр аудиторуудад заавар, зөвлөгөө өгч, хэрэгжилтийг хангууллаа.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

2021 оны эхний хагас жилд ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр 1 гүйцэтгэлийн аудитыг бүрэн хийж эцэслэсэн бөгөөд өөрийн төлөвлөгөө, хөтөлбөрөөр хийгдэж буй 2 гүйцэтгэлийн аудит хараахан эцэслэгдээгүй байна. Үүнд:

ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр:

- Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө,

Өөрийн санаачилгаар:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2020 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө,
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2020 оны зарцуулалт, үр дүн

Өөрийн санаачилгаар хийгдэж буй дээрх 2 аудитыг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу төлөвлөлт, гүйцэтгэлийн үе шатны ажлуудыг хийж дуусган тайлангийн төсөлд санал авахаар шалгагдагч байгууллагад хүргүүлсэн бөгөөд урьдчилсан гүйцэтгэлээр дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2020 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө сэдэвт аудитаар зураг төсөв, үнийн судалгаагүйгээр төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн, урсгал зардлыг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн зэрэг 882.4 сая төгрөгийн зөрчил,
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2020 оны зарцуулалт, үр дүн сэдэвт аудитаар иргэдийн саналыг тусгаагүй, зураг төсөв болон үнийн судалгаа хийлгүйгээр төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн, мэргэжлийн байгууллагаар захиалагчийн хяналтыг гүйцэтгүүлээгүй зэрэг 3,587.6 сая төгрөгийн зөрчил гэх мэт.

Гүйцэтгэлийн аудитын дүнг нэгтгэн авч үзвэл:

Албан шаардлагын биелэлт: Урьд оноос шилжиж ирсэн 605.8 сая төгрөгийн албан шаардлагыг бүрэн биелүүлсэн бөгөөд тайлант хугацаанд өгөгдсөн

2,265.2 сая төгрөгийн албан шаардлагаас 2,205.2 сая төгрөгийн зөрчлийг арилгасан талаар харилцагч байгууллагаас хариу ирүүлж, 60.0 сая төгрөгийн албан шаардлага дараагийн улиралд шилжээд байна. Ингэснээр албан шаардлагын биелэлт 97.9 хувьтай тайлагнагдлаа.

Зөвлөмжийн хэрэгжилт: Өмнөх оны үлдэгдэл 9, тайлант оны 11 зэрэг нийт 20 зөвлөмжөөс 19 зөвлөмж буюу 95.0 хувийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Гүйцэтгэлийн аудитаар 1,856.2 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцож, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлээ.

ДӨРӨВ. НИЙЦЛИЙН АУДИТ

Тайлант хугацаанд нийцлийн аудит хийгдээгүй бөгөөд өмнөх оны статистик мэдээ тайланд тусгагдаагүй, он дамжиж хийгдсэн *“Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан”*-д хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласнаар 288 нэр дэвшигчийн хууль, эрх зүйн актын шаардлага хангаагүй 93.5 сая төгрөгийн хандивын орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээ.

Акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт: Өмнөх оноос шилжиж ирсэн 11.0 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, 1,922.6 сая төгрөгийн албан шаардлага, 11 зөвлөмжийг хэрэгжүүлээд байна.

ТАВ. АЙМГИЙН ИТХ-ЫН ЗАХИАЛГА БОЛОН ӨӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ХӨТӨЛБӨРӨӨР ХИЙСЭН АУДИТ

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь хийж гүйцэтгэсэн бүх аудитын тайлан, дүнг аймгийн ИТХ-ын даргад цаасан сууриар, бүх төлөөлөгчдөд цахимаар хүргүүлж хэвшсэн болно. 2021 оны эхний хагас жилд ИТХ-д дараах тайлан мэдээллүүдийг хүргүүлээ. Үүнд:

- Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, илрүүлсэн зөрчил, цаашид анхаарах асуудлуудын талаарх товч мэдээлэл.
- Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудитын үр дүн, илрүүлсэн зөрчил, цаашид анхаарах асуудлуудын талаарх мэдээлэл.

Тус газар нь 2021 онд аймгийн ИТХ-ын захиалга, өөрийн төлөвлөгөө, хөтөлбөрөөр 3 аудит хийж гүйцэтгэхээр батлагдсан бөгөөд гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу эхний хагас жилд *“Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2020 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө”*, *“Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2020 оны зарцуулалт, үр дүн”* сэдэвт 2 гүйцэтгэлийн аудитуудыг хийж гүйцэтгэн, тайлангийн төсөлд санал авахаар шалгагдагч байгууллагуудад хүргүүлээд байна.

ЗУРГАА. ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ДОТООД АЖИЛ

Төрийн аудитын байгууллагын 2021 оны "Аудитыг цахимжуулж нэгтгэн удирдах тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх" үндсэн зорилт болон 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн тус газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зүйл, 44 арга хэмжээтэйгээр боловсруулан 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 53 дугаар албан бичгээр ҮАГ-т хүргүүлж, холбогдох албан тушаалтнаар батлуулан, мөрдөн ажиллаж байна.

2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг дэмжих дотоод ажлын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

6.1 МУ-ын Ерөнхий аудитор болон бусад удирдлагуудаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлт.

МУ-ын Ерөнхий аудитор, бусад удирдлагуудаас өгсөн дараах үүрэг, чиглэлүүдийг хэрэгжүүлэн ажиллаж, тайлагнав. Үүнд:

- МУ-ын Ерөнхий аудиторовн 2021 оны "А" тушаалуудыг хэрэгжүүлэн, хэрэгжилтийн тайланг гаргаж, ҮАГ-ын ЗУГ болон ХШҮДАГ-т тогтоосон хугацаанд нь хүргүүлэв.
- МУЕА-ын орлогчийн 2021 оны 01/450 дугаар албан бичгийн дагуу 2020 оны санхүүгийн тайланд нь "Итгэл үзүүлсэн" 30 байгууллагад албан бичиг хүргүүлээ.
- Тамгын даргын 2021 оны 03/1349, 03/1395 дугаар албан бичгүүдийн дагуу албан хаагчдын судалгаа, 14 хоногийн ажлын тайлан, хийх ажлын төлөвлөгөөг тогтоосон хугацаанд нь гаргаж, хүргүүлэв.
- СУГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу 2020 онд бичигдсэн 110 төлбөрийн акт, 233 албан шаардлагыг хуулбарлан хүргүүлсэн.
- ЗУГ-ын 2021 оны 04/08 дугаар албан бичгийн дагуу албан хаагчдын эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж, өрөө тасалгаанд 7 хоног бүр ариутгал хийж, албан хаагчдыг маск, дархлаа дэмжих витаминаар хангахад дэмжлэг үзүүлэв.
- ЗУГ-ын 2021 оны 04/1240 дугаар албан бичгийн дагуу 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1 дүгээр улирлын хэрэгжилтийн тайланг гаргаж 2021 оны 62 дугаар, 2021 оны 04/176 дугаар албан бичгийн дагуу Ерөнхий аудиторовн 2020, 2021 оны "А" тушаалуудын хэрэгжилт, үүрэг даалгаврын биелэлтийг гаргаж 2021 оны 88 дугаар албан бичгээр тус тус хүргүүлэв.
- ХШҮДАГ-ын 2021 оны 10/158 албан бичгийн дагуу зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг гаргаж 2021 оны 82 дугаар албан бичгээр, 10/180 дугаар албан бичгийн дагуу 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хавсралт хүснэгтээр гаргаж 06 сарын 08-ны өдөр файлаар, МУ-ын Ерөнхий аудиторовн 2020-2021 оны "А" тушаалуудын хэрэгжилтийн тайланг гаргаж 2021 оны 54,57 дугаар албан бичгээр тус тус хүргүүлэв.
- Аудитын 1 дүгээр газрын 2021 оны 06/1192 дугаар албан бичгийн дагуу орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн судалгааг гаргаж 2021 оны 60 дугаар, 06/131 дүгээр албан бичгийн дагуу 2020 оны санхүүгийн тайланд хийх

аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хэрэгжилтийн тайлан, холбогдох судалгааг 2021 оны 72 дугаар, 2022 онд санхүүгийн тайлангийн аудит хийх хэлбэрийн судалгаа, өөрчлөлт орсон байгууллагын судалгааг гаргаж 2021 оны 94 дүгээр албан бичгээр тус тус хүргүүлсэн

- УАГ-ын бүтцийн нэгжүүдээс зохион байгуулсан цахим уулзалтад тухай бүр оролцож, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллалаа.

6.2. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон "ТАБ-ын авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөө"-ний хэрэгжилт, байгууллагын ил тод байдал

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон "ТАБ-ын авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх, байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Төрийн тусгай 11 албан хаагч нь 2020 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдээлэв.
- Аудит эхлэхийн өмнө "Нөлөөллийн мэдүүлэг"-ийн талаар шалгадагч байгууллагад танилцуулж, баталгаажуулж хэвшсэн бөгөөд аудитын үйл ажиллагааг ашиг сонирхлын зөрчлөөс ангид гүйцэтгэж ирлээ.
- Байгууллагын шинэчлэн хийгдэж буй мэдээллийн самбарт авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах, мэдээллийн булан ажиллуулах материалыг бэлтгэж, бэлэн болгов.
- АТГ-тай хамтран ажиллаж тус газраас 2021 оны 05/2164 албан бичгээр ирүүлсэн Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төвтэй холбогдох асуудлыг шалгаж, хариуг 2021 оны 58 дугаар албан бичгээр хүргүүллээ.
- Төсвийн ил тод, нээлттэй зарчмын хүрээнд байгууллагын сар бүрийн төсвийн орлого, түүний зарцуулалт болон холбогдох бусад мэдээллийг мэдээллийн самбарт байршуулахаас гадна шилэн дансны цахим санд нийт 68 мэдээллийг хуулийн хугацаанд нь бүрэн мэдээлэв.
- Байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг ил тод байлгах зорилгоор аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан, хандив өгсөн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн жагсаалт болон 139 байгууллагын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, 68 байгууллагын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, 1 гүйцэтгэлийн аудитын тайланг *audit.mn* сайтад байршуулав.
- Төсвийн захирагчид, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит, "Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын дүн, илрүүлсэн алдаа, зөрчлийн талаар 2 удаагийн видео танилцуулга /видео шторк/ бэлтгэж, тус газрын *facebook* хуудсаар олон нийтэд түгээн, *audit.mn* сайтад байршуулав.
- Боловсон хүчин, хүний нөөцийн ил тод байдлыг хангах зорилгоор бүх албан хаагчдын хариуцсан ажил, үүрэг чиглэлийн талаарх мэдээлэл, ёс зүйн дүрмийг байгууллагын мэдээллийн самбарт байршууллаа.

6.3 Сургалт:

ҮАГ-ын сургалтын төлөвлөгөө болон өөрийн аудиторуудаас авсан санал хүсэлт, судалгааг үндэслэн тус газраас 2021 онд хийж гүйцэтгэх дотоод сургалтын төлөвлөгөөг боловсруулан, мөрдөж, дараах сургалтуудыг зохион байгуулснаар аудиторуудын мэргэжлийн мэдлэг, хийж гүйцэтгэж буй аудитын чанар, үр дүн тодорхой хэмжээгээр нэмэгдсэн гэж үзэж байна.

1. ҮАГ-аас зохион байгуулсан цахим сургалт, семинар:

- “Төрийн аудитын байгууллагын мэдээллийн нэгдсэн систем, нэвтрүүлэлт” сэдэвт онлайн сургалтад дарга, тэргүүлэх аудитор, аудитын менежер, мэдээлэл технологи хариуцсан ажилтан нар.
- Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны цахим семинарт дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа.
- Шилэн дансны нэгтгэлийн системд мэдээлэл оруулах сургалтад бүх албан хаагчид.
- Статистик мэдээний нэгтгэлийн системд мэдээлэл оруулах сургалтад бүх албан хаагчид.
- "ТАБ-аас аудит хийх журам", "Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх журам", "ТАБ-ын албан хаагчдын мөрдөх ёс зүйн журам"-ыг танилцуулах сургалтад бүх албан хаагчид.

2. Төрийн аудитын байгууллагын Сургалт хөгжлийн системийн Е-хичээлийн сангийн дараах сургалт:

- “Төрийн аудитын суурь ойлголт, стандартын хэрэглээ” сургалтад ахлах аудитор Т.Болор, аудитор Т.Одсүрэн, О.Анхбаяр, Д.Чулуунцэцэг нар хамрагдаж, үе шатны шалгалтуудыг өгөв.
- Шинэ ажилтнуудад зориулсан "Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга, хуулийн хэрэглээ" сэдэвт сургалтад аудитор Т.Мөнхзул хамрагдаж, явцын шалгалтуудад хамрагдаж байна.
- Архив, албан хэрэг хөтлөлтийн онол арга зүй болон монгол хэлний албан бичгийн найруулга, зөв бичих зүйн талаарх "Төрийн албан хэрэг хөтлөлт" сургалтад 9 албан хаагч хамрагдахаар судалгааг гаргаж хүргүүлэв.

3. Тус газрын сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан сургалт:

- 2020 оны санхүүгийн тайланд аудитад холбогдох 2020 оноос эхлэн шинээр мөрдөгдөж байгаа хууль, төсөв, хөрөнгө, бүртгэл хөтлөлттэй холбоотой Засгийн газрын тогтоол, сайдын тушаалууд.
- Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлж байсан алдаа, зөрчил түүний шийдвэрлэлт, тайлант оны санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, алдаа зөрчлийн шийдвэрлэлт.
- Санхүүгийн тайлангийн аудитын тайлан, санал дүгнэлтийн хэлбэрийг шинэчилсэн загвар.
- Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан " Акт, албан шаардлагын журам".
- 2021 онд шинээр батлагдсан хууль, Засгийн газрын тогтоол, шийдвэрүүд.
- Төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа программ хангамж, түүнийг аудитад ашиглах нь.

- Аудитын тайлан дүнг олон нийтэд цахимаар хүргэх арга зам, инфографик, видео мэдээлэл ашиглаж мэдээлэл бэлтгэх нь.
- Шинээр томилогдсон 2 аудиторт СТАУС программыг хэрэглэх талаар ажлын байран дахь сургалт хийв.



4. Бусад байгууллагаас зохион байгуулсан сургалт:

Бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтуудад дараах албан хаагчид хамрагдлаа. Үүнд:

- Төрийн албаны төв зөвлөл болон аймгийн салбар зөвлөлөөс цахимаар зохион байгуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн болон чанарын удирдлагын стандартын сургалтад төрийн тусгай 10 албан хаагч хамрагдав,
- ММНБИ-ээс зохион байгуулсан эрх сунгах цахим сургалтад аудитор Ж.Цогт хамрагдаж, 2 шалгалтын дунджаар 78.0 хувийн гүйцэтгэлтэй шалгагдав.
- ММНБИ-ээс зохион байгуулсан мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох цахим сургалтад аудитор О.Анхбаяр хамрагдаж, суурь 2 шалгалтыг амжилттай өгч /нийт 5 шалгалтаас өмнөх онд 3 шалгалтад тэнцсэн байсан/, цаашид бусад шалгалтыг өгөх эрхтэй болов.
- Архивын Ерөнхий Газар болон аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон нийтлэг журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан зохион байгуулсан сургалтад архив, бичиг хэргийн ажилтан Б.Наранцэцэг хамрагдав.

6.4 Өргөдөл, гомдол шийдвэрлэлт, харилцаа хамтын ажиллагаа:

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь орон нутгийн удирдах болон төр, төсвийн байгууллага, иргэдтэй хамтын ажиллагаа, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Өмч хувьчлал, байгууллагын санхүү төсөв, цалин хөлс зэрэг чиглэлээр Алтанбулаг, Баянгол сумдын иргэдээс ирүүлсэн 3 өргөдлийн дагуу холбогдох баримт материалыг тулган баталгаажуулж, хуулийн хугацаанд нь хариу хүргүүлэн, статистик мэдээ тайланд тусгав.
- Аймгийн ИТХ, ЗДТГ-тай хамтран 2020 оны ИТХ-ын сонгуулийн үр дүнгээр сонгогдсон сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт Төрийн аудитын тухай хууль болон төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаа, тус газраас орон нутгийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны үйл

ажиллагаа, үр дүнд хийж гүйцэтгэсэн аудитын дүнгийн талаар танилцуулга хийж, мэдээлэл өглөө.



- Боловсролын салбарын удирдах ажилтнуудад 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүн, илэрсэн алдаа, зөрчил, цаашид анхаарах асуудлын талаар мэдээлэл өгөв.
- Бүх нийтээр мод тарих аяны хүрээнд Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан мод тарих ажилд хамт олноороо идэвхтэй оролцлоо.



Байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод байлгах, хийж гүйцэтгэсэн аудитуудаар илрүүлсэн алдаа зөрчил, түүний шийдвэрлэлтийн талаар Сэлэнгэ аймгийн “Өргөн Сэлэнгэ” сэтгүүлд дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа ярилцлага өгсөн нь тайлант оны 1 дүгээр улиралд хэвлэгдэн гарсан байна.

6.5 Архив, албан бичиг хөтлөлт, албаны нууц:

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон нийтлэг журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан архивын ерөнхий газрын цахим сургалтад хамрагдаж, байгууллагын архивын өрөөг тохижуулан, албан хэрэг хөтлөлтийг холбогдох журмын дагуу гүйцэтгэн өнгөрсөн оны аудитын тайлан, ажлын баримтуудыг архивлан 52 архивын нэгж үүсгэн хадгалсан болно.

2021 оны эхний хагас жилд Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын 11 тушаал гарч, явсан бичиг 96, ирсэн бичиг 68 тус тус бүртгэгдсэн бөгөөд үүнээс 19 хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэн хүргүүлэв.

Тус газар нь нууцын зэрэглэлд багтдаг Хилийн цэргийн 0101, 0243 дугаар ангиудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийж гүйцэтгэдэг учир эдгээр байгууллагатай харьцсан ирсэн, явсан бичиг, жилийн эцсийн санхүүгийн тайлангуудыг нууцын албан тоотоор хүлээн авч, хүргүүлэн Төрийн нууцын ирсэн бичгийн дэвтэрт бүртгэлээ.

Нууцад хамаарах барим материалыг нууцын сейфэнд хадгалж, интернэт болон дотоод сүлжээнд холбогдох боломжгүй зөөврийн компьютероор бэлдэн гаргаж байгаа бөгөөд нууцтай холбогдон хөтлөгдөх 12 төрлийн бүртгэлийг тухай бүр бүртгэж байна.

Тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн аудиттай холбогдуулан 3 албан хаагч “Нууцын баталгаа” гаргаж аймгийн Тагнуулын газарт хүргүүлэв.

6.6 Хүний нөөц, шагнал урамшуулал, сахилгын шийтгэл, нийгмийн асуудлын шийдвэрлэлт:

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын нийт 12 ажилтны 50.0 хувь нь тус газарт 5-аас дээш жил ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд Ерөнхий аудиторын тушаалаар 1 аудитор нөхөн томилогдсон байна. Нийт албан хаагчдын 63.6 хувь нь мэргэшсэн нягтлан бодогчийн эрхтэй, 63.6 хувь нь магистр цолтой, жолоочоос бусад бүх ажилтнууд эдийн засаг, санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэй болно.

Тайлант онд тус газрын нийт албан хаагчдад шинэчлэн баталсан “Ёс зүйн дүрэм”-ийн талаар сургалт зохион байгуулж, судлуулан, мөрдөн ажиллаж байна. 2021 оны эхний хагас жилийн байдлаар ёс зүйн зөрчил гаргасан, сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагч байхгүй болно.

Ардын хувьсгалын 100, төрийн хяналтын байгууллага үүсэж хөгжсөний 99 жилийн ойн хүрээнд 5 албан хаагчийг төрийн одон медаль, шагнал урамшилд тодорхойлсон тодорхойлолтыг ЯАГ болон аймгийн ИТХ-д хүргүүлэв.

Төрийн жинхэнэ албан хаагч 11 ажилтан гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн үйлчилгээний албан хаагч 1 ажилтан хөдөлмөрийн гэрээ байгуулж, улирал бүр дүгнэн, тайлант хугацааны ажлын үр дүнгээр 4 албан хаагчид шинээр зэрэг дэв олгуулах, 3 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулах мэдүүлэг, танилцуулгыг ЯАГ-т хүргүүллээ.

Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд “Хөдөлмөрийн дотоод журам”-д заагдсан дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан албан хаагчдын гэр бүлд 455.0 мянган төгрөгийн бэлэг, дурсгалын зүйл олгов.
- Батлагдсан төсвийн хүрээнд сар бүр ажилтнуудад тус бүр 100.0 мянган төгрөгийн, нийт 5,875.0 мянган төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт олгов.



2020-2021 онд шинээр томилогдсон аудитор Т.Мөнхзул, О.Анхбаяр нарыг тусгай шалгалтад хамруулж, тангараг өргүүлэв.

- Байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан 3 албан хаагчийн судалгааг гаргаж, ҮАГ-т хүргүүлснээр “Хаврын тэргүүн сарын шинийн 1”-нийг тохиолдуулан тус бүр 100.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон байна.
- Шинээр хүүхэд төрүүлсэн ахлах аудитор Ц.Отгонбаярт хамт олны зүгээс 200.0 мянган төгрөгийн тусламж олгов.
- Ковид-19 өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд албан хаагчдыг амны хаалт, нэг удаагийн бээлий, ажлын ачаалал ихтэй үед халуун аарц, жимсний шүүсээр хангах арга хэмжээ авч, өрөө тасалгааг тогтмол ариутган, халдваргүйжүүлэн, батлагдсан төсвөөс 455.0 мянган төгрөгийг зарцуулаад байна.

ДОЛОО. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ТАЙЛАГНАЛ

Тус газрын 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд 251.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас урьдчилсан гүйцэтгэлээр 196.8 сая төгрөгийг зарцуулж, 78.1 хувийн гүйцэтгэлтэй, өр төлбөр, авлагагүй тайлагнагдаж байна.

Батлагдсан төсвөөс цалин хөлсний зардал 43.4 сая төгрөгөөр, НДШ-ийн зардал 4.6 сая төгрөгөөр, албан томилолтын зардал 1.6 сая төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж 1.9 сая төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал 0.9 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 1,1 сая төгрөгөөр тус тус хэмнэгдэж байна.

НДШ-ийн тайланг сар бүр, ХХОАТ-ын тайланг улирлаар гарган, холбогдох байгууллагуудад хүргүүлж, нийгмийн даатгалын шимтгэл, татварын өр, авлагагүй тайлагнагдсан.

Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, тайлан, 2022-2023 оны төсвийн төсөл, төсвийн хүрээний мэдэгдлийг холбогдох маягт, аргачлалын дагуу гаргаж тус тус тогтоосон хугацаанд нь ҮАГ-ын СХОГ-т хүргүүллээ.

2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд гарган, “Мишээл од” компаниар аудит хийлгүүлж, “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан байна.

Байгууллагын 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан гаргахтай холбогдуулж, дарга, тэргүүлэх аудиторовын 2021 оны А/07 дугаар тушаалаар томилогдсон “Эд хөрөнгийн тооллогын комисс” хөрөнгийн тооллого хийж, эзэмшүүлэх картыг шинэчлэн хөтлөв.

Тайлант хугацаанд батлагдсан төсвийн хүрээнд 1.8 сая төгрөгийн шатахуун, 1.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал зэргийг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн бөгөөд шууд худалдан авах босго үнээс давсан худалдан авах ажиллагаа хийгдээгүй байна.

НАЙМ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Дүгнэлт: Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд эхний хагас жилд хэрэгжүүлэхээр тусгагдсан ажил, үйлчилгээг бүрэн буюу 100.0 хувийн биелэлттэй хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд:

- Үндсэн чиг үүргийн 24 арга хэмжээний хэрэгжилтийг ханган, 298 санхүүгийн тайлан, 1 гүйцэтгэлийн аудитын үр дүнгээр тогтоосон акт 87.0 хувийн, албан шаардлага 94.9 хувийн, зөвлөмж 88.7 хувийн биелэлттэй тайлагнагдав.
- Үйл ажиллагааг дэмжих, дотоод чиг үүргийн зорилтын хүрээнд төлөвлөсөн 12 ажил, үйлчилгээг бүрэн хэрэгжүүлэв.

ЕС. ХАВСРАЛТУУД

Тус газрын 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланд дараах мэдээ, тайлан, судалгааг хавсаргав. Үүнд:

- 2021 оны эхний хагас жилийн статистик мэдээ,
- Аудитаас бий болсон үр өгөөжийн тайлангийн нэгтгэлийг УАГ-1135 маягтаар гаргасан судалгаа,
- Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагын хэрэгжилтийн дэлгэрэнгүй судалгаа зэрэг болно.

	ТАЙЛАН ХЯНАСАН:	
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Ч.ЭНХТУЯА
	БОЛОВСРУУЛСАН:	
АУДИТЫН МЕНЕЖЕР		Б.БАТМӨНХ

4317143998
МНОА0065 9055436

Сэлэнгэ аймаг дахь Төрийн Аудитын газраас 2021 оны эхний хагас жилд хариуцлага тооцуулах санал хүргүүлсэн болон хуулийн байгууллагад шилжүүлсэн асуудлын дэлгэрэнгүй судалгаа

1. Албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал

№	Байгууллагын нэр	Албан тушаалтны нэр	Албан тушаал	Зөрчлийн утга	Хаана хандсан	Хэрэгжсэн /тийм/ хэрэгжээгүй /гүй/
1	Сэлэнгэ Энерго ОНӨААТҮГ	Э.Эрдэнэбаатар	Захирал	Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан	Аймгийн Засаг дарга	Хугацаа болоогүй
2	Урсгал ус ХХК	А.Алтансүх	Захирал	Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан	Аймгийн Засаг дарга	Хугацаа болоогүй
3	Гавшгай ус ХХК	Л.Балдорж	Захирал	Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан	Аймгийн Засаг дарга	Хугацаа болоогүй
4	Сэлэнгэ Орон сууц ОНӨААТҮГ	М.Тэмүүлэн	Дарга	Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан	Аймгийн Засаг дарга	Хугацаа болоогүй
5	Мандал Энерго ОНӨААТҮГ	Д.Цэрэндагва	Дарга	Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан	Сумын Засаг дарга	Тийм
6	Туулын Хишиг ОНӨААТҮГ	С.Эрдэнэчулуун	Дарга	Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан	Сумын Засаг дарга	Тийм
7	Орхонтуул сумын ЗДТГ	Ш.Өнөрбаяр	Дарга	Өмнөх аудитаар тогтоосон актын төлбөрийг барагдуулаагүй	Сумын Засаг дарга	Тийм
8	Хүдэр сумын ЭМТ	М.Ганзаяа	Дарга	Албан үүргээ хангалтгүй гүйцэтгэж, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд их хэмжээний материаллаг зөрчил гаргасан	Сумын Засаг дарга	Тийм
9	Зүүнбүрэн сумын ЭМТ	О.Халиун	Дарга	Албан үүргээ хангалтгүй гүйцэтгэж, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд их хэмжээний материаллаг зөрчил гаргасан	Сумын Засаг дарга	Тийм
10	Зүүнбүрэн сумын ЭМТ	Н.Хувьзаяа	Нягтлан бодогч	Албан үүргээ хангалтгүй гүйцэтгэж, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд их хэмжээний материаллаг зөрчил гаргасан	Сумын Засаг дарга	Тийм
11	Орхон	Ш.Ганчимэг	Дарга	Өмнөх аудитаар өгсөн		Тийм

	сумын ЗДТГ			албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан	Сумын Засаг дарга	
12	Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэг	Ц.Орхонцэцэг	Эрхлэгч	Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан	Сумын Засаг дарга	Тийм
13	Сүхбаатар сумын 5 дугаар цэцэрлэг	Б.Одонтуяа	Нягтлан бодогч	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс нээлгээгүй	Цэцэрлэгийн эрхлэгч	Тийм
14	Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэг	Х.Бат-Эрдэнэ	Нягтлан бодогч	Албан үүргээ хангалтгүй гүйцэтгэж, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд их хэмжээний материаллаг зөрчил гаргасан	Цэцэрлэгийн эрхлэгч	Тийм
15	Шаамар сумын Дулаанхаан тосгоны цэцэрлэг	Д.Энхмаа	Эрхлэгч	Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан	Сумын Засаг дарга	Тийм
16	Шаамар сумын Дулаанхаан тосгоны цэцэрлэг	Г.Алтанзул	Нягтлан бодогч	Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан	Сумын Засаг дарга	Тийм
17	Шаамар сумын ЭМТ	Б.Алтанцэцэг	Дарга	Албан үүргээ хангалтгүй гүйцэтгэж, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд их хэмжээний материаллаг зөрчил гаргасан	Сумын Засаг дарга	Тийм
18	Шаамар сумын ЭМТ	Б.Эрдэнэтуяа	Нягтлан бодогч	Албан үүргээ хангалтгүй гүйцэтгэж, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд их хэмжээний материаллаг зөрчил гаргасан	Сумын Засаг дарга	Тийм
19	Шаамар сумын Дулаанхаан тосгоны ЭМТ	Г.Алтанцэцэг	Дарга	Албан үүргээ хангалтгүй гүйцэтгэж, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд их хэмжээний материаллаг зөрчил гаргасан	Сумын Засаг дарга	Тийм
20	Шаамар сумын Дулаанхаан тосгоны ЭМТ	М.Амарсайхан	Нягтлан бодогч	Албан үүргээ хангалтгүй гүйцэтгэж, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд их хэмжээний материаллаг зөрчил гаргасан	Сумын Засаг дарга	Тийм

СУДАЛГАА ГАРГАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ

ТАНИЛЦСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА



Аудитын үр өгөөжийн тайлангийн нэгтгэл

Тайлант жил: 2021 оны эхний хагас жил		Аудитын газар: Сэлэнгэ аймаг дахь Төрийн Аудитын газар		Аудитын менежер: <u>Б.Батмөнх</u> / Б.Батмөнх /		Дарга, тэргүүлэх аудитор: <u>М.Бат</u> / Ч.Энхтүяа /	
№	Аудитын нэр, код	Аудитын код	Аудитын үр өгөөжийн товч утга	Үр өгөөжийн нийт үнэлгээ / сая төгрөгөөр/	Тайлбар		
1			Билэг ДБ хувийн сургуулийн хувьсах зардлын санхүүжилтийг илүү шилжүүлснийг нөхөн төлүүлэв..	60.4			
2	Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн СТА	СЭА-2021/1/СТА-ТЕЗ	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг таслан зогсоов.	253.0			
3			Орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийн хууль, эрх зүйн акт зөрчсөн хандивын орлогыг төсөвт төвлөрүүлэв.	93.5			
4			Зөвлөмжийг хэрэгжүүлснээр татварын авлагыг бууруулав.	1,091.0			
5	Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн СТА	СЭА-2021/2/СТА-ТТЗ	Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлээс нөхөн төлүүлэв.	25.7			
6			Илүү тооцож олгосон урамшууллыг нөхөн төлүүлэв.	0.7			
7	Орхон сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн СТА	СЭА-2021/3/СТА-ТТЗ	Цалин хөлсийг илүү олгосныг нөхөн төлүүлэв.	0.8			
8			Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлээс нөхөн төлүүлэв.	27.4			
9			Үндэслэлгүйгээр олгосон нэмэгдэл цалинг нөхөн төлүүлэв.	0.4			
10	Түшиг сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн СТА	СЭА-2021/4/СТА-ТТЗ	Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэв.	1.1			
11			Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлээс нөхөн төлүүлэв.	14.0			
12			Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэв.	0.5			
13	Цагааннуур сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн СТА	СЭА-2021/5/СТА-ТТЗ	Тэтгэвэр тогтоолгосон албан хаагчдад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг илүү олгосныг нөхөн төлүүлэв.	1.4			
14			Эмийн орлогыг дууту төвлөрүүлснийг нөхөн төлүүлэв.	1.1			
15			Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлээс нөхөн төлүүлэв.	48.9			
16			Орон нутгийн төсвийн давсан орлогыг зарцуулах эрх үүсвэргүй байхад зарцуулсан зөрчлийг таслан зогсоов	3.4			
17			Төсвийг үр ашгийг зарцуулсан зөрчлийг таслан зогсоов.	6.1			
18	Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн СТА	СЭА-2021/06/СТА-ТТЗ	Төсөвт өр төлбөр үүсгэж, хэрэгцээнээс илүү нөөц үүсгэсэн зөрчлийг таслан зогсоов.	31.1			
19			Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлээс нөхөн төлүүлэв.	15.8			
20			Бэлчээрийн төлбөрийг төсвийн орлогод төвлөрүүлснийг зөрчлийг таслан зогсоов.	12.6			
21			Цалингийн нэмэгдлийг илүү тооцож олгосныг нөхөн төлүүлэв.	1.7			
22	Хушаат сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн СТА	СЭА-2021/7/СТА-ТТЗ	Батлагдсан эмийн зардлыг хэтрүүлэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоов.	5.3			

23				Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлээс нөхөн төлүүлэв.	17.4
24	Шаамар сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн СТА	СЭА-2021/8/СТА-ТТЗ		Эмийн сангийн орлогыг дутуу төвлөрүүлснийг нөхөн төлүүлэв.	14.2
25				Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлээс нөхөн төлүүлэв.	34.5
26	Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн СТА	СЭА-2020/9/СТА-ТТЗ		Эмийн орлогыг дутуу төвлөрүүлснийг нөхөн төлүүлэв.	2.3
27				Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг давхардуулан олгосон зөрчлийг таслан зогсоов.	11.0
28	Жавхлант сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн СТА	СЭА-2021/10/СТА-ТТЗ		Зайлшгүй шаардлага үүсээгүй байхад төсвийн тодотгол хийж, урсгал зардлыг нэмэгдүүлэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоов.	3.5
29				Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлээс нөхөн төлүүлэв.	11.9
30	Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн СТА	СЭА-2021/11/СТА-ТТЗ		Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тогтоосон хувь хэмжээнээс илүү олгосныг нөхөн төлүүлэв.	0.8
31				Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлээс нөхөн төлүүлэв.	59.7
32	Ерөө сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн СТА	СЭА-2020/12/СТА-ТТЗ		Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсныг нөхөн төлүүлэв.	0.8
33				Эмийн орлогыг дутуу төвлөрүүлснийг нөхөн төлүүлэв.	3.9
34				Цалингийн урьдчилгааг дутуу суутгасныг нөхөн төлүүлэв.	0.5
35	Баянгол сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн СТА	СЭА-2021/13/СТА-ТТЗ		Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийг нөхөн төлүүлэв.	35.6
36				Төсвийн тодотгол хийж, урсгал зардлыг нэмэгдүүлэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоов.	28.0
37	Хүдэр сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн СТА	СЭА-2021/14/СТА-ТТЗ		Батлагдсан эмийн зардлыг хэтрүүлэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоов.	6.3
38				Хавсран ажилласны нэмэгдлийг илүү тооцож, олгосныг нөхөн төлүүлэв.	0.5
